

**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
**ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2013 ОНЫ 3 ДУГААР**  
**УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ**  
**АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

**ТАНИЛЦСАН:**

ХОРООНЫ ДАРГА	Д. БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Г. ХЭРЛЭН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМБА
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х. БУМ-ЭРДЭНЭ

**ХЯНАСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С. ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН БТХ-ИЙН ДАРГА	П. ЦЭРЭНДЭЖИД

**БОЛОВСРУУЛСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э. ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	---------------

УЛААНБААТАР ХОТ

2013.11.15

## ГАРЧИГ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

### ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ
- 2.10 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТАЛААР

### ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

### ДҮГНЭЛТ

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2013 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН  
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА  
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**

**1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

2013 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 240 даатгалын салбар, 3143 даатгалын төлөөлөгч, 19 даатгалын зуучлагч компани, 11 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3205 тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна. (Хүснэгт-1)

**Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

№	Он	2009-III	2010-III	2011-III	2012-III	2013-III
1	Даатгагч	17	16	17	18	17
2	Даатгалын компанийн салбар	130	136	152	219	240
3	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар					6
4	Даатгалын төлөөлөгч	1639	1998	2080	2436	3143
5	Даатгалын зуучлагч	4	8	8	13	19
6	Даатгалын зуучлагч компанийн салбар					36
7	Даатгалын хохирол үнэлэгч		6	8	9	11
8	Актуарч		10	12	15	15
9	Жолоочийн даатгалын зөвшөөрөл					16
	<b>Бүгд</b>	1660	2038	2125	2491	3205

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь энэ оны 3 дугаар улирлын байдлаар 2009 оны мөн үеэс 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнд мэргэжлийн оролцогчдын тооны өсөлт нөлөөлсөн байна. (График-1)




Даатгалын компанийн төлөөлөгчийн газар өмнөх оны мөн үеийнхээс 6-аар нэмэгдсэн нь “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт орсонтой холбоотой. Тайлант үед даатгалын мэргэжлийн оролцогч компаниуд үйл ажиллагаагаа өргөтгөж, салбарууд шинээр байгуулж эхлээд байна.

## 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2013 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 122.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.8 тэрбум төгрөг буюу 1.2 дахин өссөн байна. Мөн өмнөх 5 жилийн мөн үетэй харьцуулахад 83.4 тэрбум төгрөг буюу 3.1 дахин өссөн дүнтэй байна.

(График-2/



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2012 оны 3 дугаар улиралд 83.5 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 83.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 17.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 20.7 хувийг эзэлж байсан бол 2013 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 105.5 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 86.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17.1 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 14.0 хувийг эзэлж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 22.0 тэрбум төгрөг буюу 1.2 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм.

### Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

2013 оны 3 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 61.72 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 20.89 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 14.54 хувийг дансны авлага, үлдэх 2.85 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 7.04 пунктээр

буурч, дансны авлага 1.37 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 0.24 пунктээр, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 5.44 пунктээр тус тус өссөн байна.

(Хүснэгт-2)

**Эргэлтийн хөрөнгө**

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2012-03 улирал		2013-03 улирал		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	47 014,80	56,28	65 114,20	61,72	18 099,40	5,44
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	23 335,90	27,93	22 042,50	20,89	(1 293,40)	(7,04)
<b>Дансны авлага</b>	11 002,80	13,17	15 340,70	14,54	4 337,90	1,37
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	2 183,40	2,61	3 006,20	2,85	822,80	0,24
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>83 536,90</b>	<b>100,00</b>	<b>105 503,60</b>	<b>100,00</b>	<b>21 966,70</b>	<b>0,00</b>

2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 24.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 19.8 хувийг, “Гэр даатгал” ХХК хамгийн бага буюу 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 2.3 хувийг эзэлж байгаа бол эхний 3 компани нийт хөрөнгийн 38.0 хувийг эзэлж, даатгалын салбар дахь хөрөнгийн төвлөрлийн хэмжээ буурсан байна.

(Хүснэгт-3)


/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	8 456,8	6,9
2	Бодь даатгал ХХК	12 555,2	10,2
3	Ган зам даатгал ХХК	3 279,9	2,7
4	Мандал женерал даатгал ХХК	9 628,2	7,9
5	МИГ даатгал ХХК	6 771,9	5,5
6	Монгол даатгал ХХК	24 284,4	19,8
7	Гэр даатгал ХХК	2 786,7	2,3
8	Моннис даатгал ХХК	3 866,8	3,2
9	Мөнх даатгал ХХК	3 018,5	2,5
10	Номин даатгал ХХК	6 494,3	5,3
11	Нэйшнл лайф даатгал ХХК	4 895,3	4,0
12	Практикал даатгал ХХК	7 383,8	6,0
13	Тэнгэр даатгал ХХК	8 525,8	7,0
14	Соёмбо даатгал ХХК	6 211,2	5,1
15	Монре даатгал ХХК	6 766,4	5,5
16	УБ хотын даатгал ХХК	3 911,1	3,2

17	Хаан даатгал ХХК	3 805,7	3,1
	<b>ДҮН</b>	<b>122 642,0</b>	<b>100,0</b>

### 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 3 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна. /График-3/



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2011 оны 3 дугаар улиралд 44.9 хувь, 2012, 2013 оны 3 дугаар улиралд тус тус 47.0 хувьтай байгаа бөгөөд харин өр төлбөрийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 1.6 дахин өссөн байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн эзэмшигчдийн өмчийн дүнд эзлэх дүн 2012 онд 72.64 хувь байсан бол тайлант онд 74.55 хувь болж 1.91 пунктээр өссөн байна. Мөн бусад өмчийн нийт эзэмшигчдийн өмчид эзлэх дүн 2.85 пунктээр өсч, харин хуримтлагдсан ашиг тайлант оны мөн үеийнхээс 4.76 пунктээр буурсан байна.

(Хүснэгт-4)

#### Эзэмшигчдийн өмч

Санхүүгийн үзүүлэлт	2012 - III		2013 - III		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Хувь нийлүүлсэн хөрөнгө	35 881,70	72,64	41183,3	74,55	5301,6	1,91
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	9 028,70	18,28	7467,2	13,52	-1561,5	(4,76)
Бусад өмчийн хэсэг	4 489,10	9,09	6594,8	11,94	2105,7	2,85
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>49 399,50</b>	<b>100</b>	<b>55245,3</b>	<b>100</b>	5845,8	

Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн 2012 оны мөн үеийнхтэй харьцуулахад 7.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хуримтлагдсан ашиг сүүлийн 2 жилд тогтвортой нэмэгдэж байсан ч тайлант оны мөн үед 1.5 тэрбум төгрөгөөр буурсан нь “Нэйшнл лайф даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК-иудын хуримтлагдсан алдагдал нь даатгалын компаниудын цэвэр ашгийг бууруулж байна.

#### 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2013 оны 3 дугаар улиралд 67292.6 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.12 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 66,604.7 сая төгрөг, урт хугацааны даатгагч 687.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 7116.7 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 687.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 20100.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын хэлбэрээр 2013 оны 3 дугаар улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.4 дахин, хөрөнгийн даатгал 1.2 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.0 дахин, ачааны даатгал 1.3 дахин, барилга угсралтын даатгал 2.1 дахин, мал амьтадын даатгал 23.6 дахин, агаарын хөлгийн даатгал 0.9 дахин, хариуцлагын даатгал 1.0 дахин, санхүүгийн даатгал 1.3 дахин, жолоочийн хариуцлагын даатгал 0,8 дахин тус тус нэмэгдэж, зээлийн даатгал, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариулагын даатгал шинээр хийгдсэн бөгөөд ердийн даатгалын даатгалын компаниудын даатгалын нийт хураамжийн орлогын өсөлт 112 хувьтай байна.

(Хүснэгт-5)  
/сая төгрөгөөр/

№	Даатгалын хэлбэр	2012.09.30	2013.09.30	Өсөлт бууралт /дахин/
		Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)		
1,1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	4 655,00	6 649,60	1,4
1,2	Хөрөнгийн даатгал	14 549,60	17 690,00	1,2
1,3	Автотээврийн хэрэгслийн даатгал	11 569,90	11 930,70	1,0
1,4	Ачааны даатгал	1 101,30	1 479,30	1,3
1,5	Барилга угсралтын даатгал	1 829,10	3 774,20	2,1
1,6	Газар тариалангийн даатгал	0,00	-	
1,7	Мал амьтдын даатгал	8,00	188,80	23,6
1,8	Агаарын хөлгийн даатгал	5 803,70	5 457,90	0,9
1,9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		232,80	
1,1	Хариуцлагын даатгал	5 316,10	5 149,90	1,0
1,11	Санхүүгийн даатгал	1 306,40	1 731,80	1,3
1,12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	13 348,90	10774,60	0,8
1,13	Зээлийн даатгал		1 459,00	
1,14	Итгэлцлийн даатгал		-	
1,15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал		-	

<b>1,16</b>	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		-	
<b>1,17</b>	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		86,10	
	<b>Ердийн даатгалын дүн</b>	<b>59 488,00</b>	<b>66 604,70</b>	<b>1.12</b>
<b>2,1</b>	Хугацаат амьдралын даатгал	211,20	265,3	1,3
<b>2,2</b>	Насан туршийн даатгал			
<b>2,3</b>	Хуримтлалын даатгал	90,60	67,1	0,7
<b>2,4</b>	Тэтгэврийн даатгал	26,50	44,4	1,7
<b>2,5</b>	Эрүүл мэндийн даатгал	102,00	311,1	3,1
<b>2,6</b>	Аннуити даатгал			
	<b>Урт хугацааны даатгалын дүн</b>	<b>430,30</b>	<b>687,9</b>	<b>1,6</b>
	<b>Нийт дүн</b>	<b>59 918,30</b>	<b>67 292,60</b>	<b>1.12</b>

### 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2013 оны 3 дугаар улиралд нийт 17401.6 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосноос 3755.3 сая төгрөгийг давхар даатгалаас нөхөн төлүүлсэн бөгөөд, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.3 дахин, хөрөнгийн даатгал 1.7 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.1 дахин, ачааны даатгал 1.4 дахин, барилга угсралтын даатгал 2.4 дахин, мал амьтадын даатгал 23.6 дахин, агаарын хөлгийн даатгал 0.9 дахин, хариуцлагын даатгал 0.5 дахин, санхүүгийн даатгал 0.6 дахин, жолоочийн хариуцлагын даатгал 2.8 дахин тус тус өссөн бөгөөд ердийн даатгалын даатгалын компаниын даатгалын нийт хураамжийн орлогын өсөлт 1.7 дахин нэмэгдсэн байна. Урт хугацааны даатгалын компанийн хугацаат амьдралын даатгал 0.9 дахин, хуримтлалын даатгал 1.3 дахин, тэтгэврийн даатгал 0.7 дахин, эрүүл мэндийн даатгал 2.2 дахин тус тус нэмэгдэж нийт хэмжээгээр 140.0 хувиар өссөн байна.

(Хүснэгт-6)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын хэлбэр	12.09.30	13.09.30	Өөрчлөлт
		Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
<b>1,1</b>	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1 201,70	1509,5	1,3
<b>1,2</b>	Хөрөнгийн даатгал	1 092,10	1802,7	1,7
<b>1,3</b>	Автотээврийн хэрэгслийн даатгал	4 238,10	4851,5	1,1
<b>1,4</b>	Ачааны даатгал	153,40	209,6	1,4
<b>1,5</b>	Барилга угсралтын даатгал	11,20	26,7	2,4
<b>1,6</b>	Газар тариалангийн даатгал			0,0
<b>1,7</b>	Мал амьтдын даатгал		57,7	0,0
<b>1,8</b>	Агаарын хөлгийн даатгал	8,70	7,7	0,9
<b>1,9</b>	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		15,2	0,0
<b>1,1</b>	Хариуцлагын даатгал	406,10	200,2	0,5
<b>1,11</b>	Санхүүгийн даатгал	756,40	417,2	0,6



1,12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	2 231,10	6940,4	3,1
1,13	Зээлийн даатгал		1167	0,0
1,14	Итгэлцлийн даатгал			0,0
1,15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал			0,0
1,16	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			0,0
1,17	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			0,0
	Ердийн даатгалын дүн	<b>10 098,80</b>	<b>17205,4</b>	1,7
2,1	Хугацаат амьдралын даатгал	39,00	36,7	0,9
2,2	Насан туршийн даатгал			0,0
2,3	Хуримтлалын даатгал	53,10	68,4	1,3
2,4	Тэтгэврийн даатгал	4,00	2,9	0,7
2,5	Эрүүл мэндийн даатгал	39,60	88,2	2,2
2,6	Аннуити даатгал			0,0
	Урт хугацааны даатгалын дүн	<b>135,70</b>	<b>196,2</b>	1,4
	<b>Нийт дүн</b>	<b>10 234,50</b>	<b>17 401,60</b>	<b>1,7</b>

## 1.6 ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

2013 оны 3 дугаар улиралд даатгалын хохирлын харьцаа даатгалын салбарын дүнгээр 40.4 хувь болж 2012 оны мөн үеийнхээс 10.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 33.5 хувьтай байна.

(График-4)



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирлын харьцаагаар харьцуулахад 2013 оны 3 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 36.6 хувь, “Соёмбо даатгал” ХХК 35.5 хувь, “Ард даатгал” ХХК 34.2 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-7)

№	Даатгалын компаниудын нэрс	Даатгалын хохирлын харьцаа		Өсөлт бууралт /пунктээр/
		12.09.30	13.09.30	
1	Ард даатгал ХХК	34,2	34,6	0,36
2	Бодь даатгал ХХК	28,2	36,0	7,84
3	Ган зам даатгал ХХК	4,5	8,9	4,41
4	Мандал женерал даатгал ХХК	0,0	27,8	27,76
5	МИГ даатгал ХХК	33,6	49,0	15,36
6	Монгол даатгал ХХК	36,6	49,1	12,49
7	Гэр даатгал ХХК	22,0	31,5	9,55
8	Моннис даатгал ХХК	14,4	12,0	-2,31
9	Мөнх даатгал ХХК	14,0	23,4	9,42
10	Номин даатгал ХХК	30,4	46,1	15,64
11	Нэйшнл лайф даатгал ХХК	31,6	28,5	-3,10
12	Практикал даатгал ХХК	21,0	46,6	25,60
13	Тэнгэр даатгал ХХК	25,7	35,9	10,20
14	Соёмбо даатгал ХХК	35,5	51,6	16,11
15	Монре даатгал ХХК	18,6	45,3	26,79
16	УБ хотын даатгал ХХК	12,6	5,6	-7,04
17	Хаан даатгал ХХК	0	24,7	24,69
	ДҮН	<b>29,7</b>	<b>40,4</b>	<b>10,69</b>

Даатгалын компаниудын тайлант үеийн даатгалын хохирлын харьцааг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 0.36 пунктээр, “Бодь даатгал” ХХК 7.84 пунктээр, “Ган зам даатгал” ХХК 4,41 пунктээр, “Мандал женерал даатгал” ХХК 27.76 пунктээр, “Миг даатгал” ХХК 15.36 пунктээр, “Монгол даатгал” ХХК 12.49 пунктээр, “Гэр даатгал” ХХК 9.55 пунктээр, , “Мөнх даатгал” ХХК 9.42 пунктээр, “Номин даатгал” ХХК 15.64 пунктээр, , “Практикал даатгал” ХХК 25.60 пунктээр, , “Тэнгэр даатгал” ХХК 10.20 пунктээр, “Монре даатгал” ХХК 26,79 пунктээр “Соёмбо даатгал” ХХК 16,11 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 10.20 пунктээр, “Хаан даатгал” ХХК 24.69 пунктээр тус тус нэмэгдэж, “Нэйшнл лайф даатгал“ ХХК 3,10 пунктээр, “Моннис даатгал” ХХК 2.31 пунктээр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК 7,04 пунктээр тус тус буурсан байна.

### 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 4622.1 сая төгрөг байна.


(Хүснэгт-8)

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		Өсөлт, бууралт
		12.09.30	13.09.30	

1	Ард даатгал ХХК	299,7	2 059,5	6,9
2	Бодь даатгал ХХК	370,7	281,0	0,8
3	Ган зам даатгал ХХК	339,4	385,1	1,1
4	Мандал женерал даатгал ХХК	(61,5)	517,2	-8,4
5	МИГ даатгал ХХК	524,2	101,3	0,2
6	Монгол даатгал ХХК	1 216,5	433,5	0,4
7	Гэр даатгал ХХК	12,5	126,5	10,1
8	Моннис даатгал ХХК	509,4	222,8	0,4
9	Мөнх даатгал ХХК	60,9	110,7	1,8
10	Номин даатгал ХХК	464,6	33,9	0,1
11	Нэйшнл лайф даатгал ХХК	(142,2)	(37,2)	0,3
12	Практикал даатгал ХХК	585,3	73,0	0,1
13	Тэнгэр даатгал ХХК	612,5	599,2	1,0
14	Соёмбо даатгал ХХК	132,5	62,0	0,5
15	Монре даатгал ХХК	177,8	80,3	0,5
16	УБ хотын даатгал ХХК	118,7	99,2	0,8
17	Хаан даатгал	(27,1)	(525,9)	19,4
	<b>Дүн</b>	<b>5 193,9</b>	<b>4 622,1</b>	<b>0,9</b>

Тайлант оны мөн үеийн цэвэр ашгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 6.9 дахин , “Гэр даатгал” ХХК 10.1 дахин нэмэгдсэн байна. Тайлант онд “Нэйшнл лайф даатгал” ХХК 37.2 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 525.6 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

(График-5)




Хуримтлагдсан ашгийн хэмжээ 2011 оноос тогтвортой өсч ирсэн хэдий ч 2013 оны 03 дугаар улирлын байдлаар хуримтлагдсан ашгийн хэмжээ 4721.4 сая төгрөг болж буурсан байна.

### 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2010 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц 26.7 тэрбум байсан бол 2011 оны мөн үед 34.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 8.0

тэрбумаар нэмэгдсэн байна. 2013 оны мөн үед даатгалын нөөц сангийн үлдэгдэл 2012 оны мөн үеийнхээс 11.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

(График-6)



### 1.9 ДАВХАР ДААТГАЛ

2013 оны 3 дугаар улиралд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 18.4 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 2.1 тэрбум төгрөгөөр буюу 1.1 дахин өссөн дүнтэй гарсан байна.

(График-7)



(Хүснэгт-10)

(сая төгрөгөөр)

№	Компанийн нэр	2012-III		2013-III		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал	2683	16,42	1181,2	6,40	-1501,8	(10,02)
2	Бодь даатгал	4305,6	26,34	2918	15,81	-1387,6	(10,54)
3	Тэнгэр даатгал	571,6	3,50	2970,2	16,09	2398,6	12,59
4	Практикал даатгал	145,4	0,89	170	0,92	24,6	0,03
5	Миг даатгал	1487,9	9,10	1706,9	9,25	219	0,14
6	Монгол даатгал	3740,8	22,89	5126,9	27,78	1386,1	4,89
7	Номин даатгал	25,6	0,16	36,6	0,20	11	0,04
8	Нэйшнл лайф даатгал	11,2	0,07	36,1	0,20	24,9	0,13
9	Монре даатгал	65,7	0,40	86,6	0,47	20,9	0,07
10	Соёмбо даатгал	1196,5	7,32	300,6	1,63	-895,9	(5,69)
11	УБ хотын даатгал		-		-	0	-
12	Ган зам даатгал	170,5	1,04		-	-170,5	(1,04)
13	Моннис даатгал	1077,7	6,59	1041,8	5,64	-35,9	(0,95)
14	Мандал женерал даатгал ХХК	861,9	5,27	2883,5	15,62	2021,6	10,35
		<b>16343,4</b>	<b>100</b>	<b>18458,4</b>	<b>100</b>	<b>2115</b>	

2013 оны 3 дугаар улиралд гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2012 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Тэнгэр даатгал” ХХК 2398.6 сая төгрөгөөр, “Практикал даатгал” ХХК 24.6 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 219.0 сая төгрөгөөр, “Монгол даатгал” ХХК 1386.1 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 11.0 сая төгрөгөөр, “Монре даатгал” ХХК 20.9 сая төгрөг, “Мандал женерал даатгал” ХХК 2021.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, “Ард даатгал” ХХК 1501.8 сая төгрөгөөр, “Бодь даатгал” ХХК 1387.6 сая төгрөгөөр “Ган зам даатгал” ХХК 170.5 сая төгрөгөөр, “Моннис даатгал” ХХК 35.9 сая төгрөгөөр, “Нэйшнл лайф даатгал” ХХК нь 11.2 сая төгрөгөөр, “Соёмбо даатгал” ХХК 895.9 сая төгрөгөөр, тус тус бууруулсан байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

### 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ

2013 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 17 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 240 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 21-ээр нэмэгдсэн байна.


### 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 17 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 117.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн

үеийнхээс 20.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.  
(График-8)

### Ердийн даатгагчийн нийт хөрөнгийн хэмжээ

/тэрбум төгрөгөөр/



### 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Тайлантт оны эзэмшигчдийн өмчийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 4735.7 сая төгрөгөөр өссөн бөгөөд 1.1 дахин нэмэгдсэн байна.

(Хүснэгт-11)

/сая төгрөгөөр/

Санхүүгийн үзүүлэлт	2012 - III		2013 - III		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө	32 531,70	69,97	37833,3	73,85	5301,6	3,88
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	9 817,40	21,12	8274,7	16,15	-1542,7	(4,96)
Бусад өмчийн хэсэг	4 145,50	8,92	5122,3	10,00	976,8	1,08
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>46 494,60</b>	<b>100</b>	<b>51230,3</b>	<b>100</b>	4735,7	

Энэ оны эзэмшигчийн өмчийн нийт дүн өмнөх оны мөн үеийнхээс өссөн нь Хорооноос даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоож өгсөнтэй холбоотой.

### 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант үед ердийн даатгалын компаниуд 66,604.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнээс 27.7 хувийг давхар даатгалд 18422.3 сая төгрөг, 0.5 хувийг буюу 325.3 сая төгрөгийг буцаасан даатгалын хураамжид төлж, 47857.1 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2013 оны 3 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 28.2 хувь буюу 18787.5 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 14.0 хувь буюу 9350.2 сая төгрөгийг, “Тэнгэр даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 10.1 хувь буюу 6730.9 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 52.3 хувийг эзэлсэн байна.

(Хүснэгт-

12)

№	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	/сая төгрөгөөр/
			Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	6 165,7	9,3
2	Бодь даатгал ХХК	9 350,2	14,0
3	Ган зам даатгал ХХК	512,1	0,8
4	Мандал женерал даатгал ХХК	5 701,6	8,6
5	МИГ даатгал ХХК	5 030,7	7,6
6	Монгол даатгал ХХК	18 787,5	28,2
7	Гэр даатгал ХХК	310,1	0,5
8	Моннис даатгал ХХК	1 427,0	2,1
9	Мөнх даатгал ХХК	517,2	0,8
10	Номин даатгал ХХК	1 100,7	1,7
11	Практикал даатгал ХХК	2 806,8	4,2
12	Тэнгэр даатгал ХХК	6 730,9	10,1
13	Соёмбо даатгал ХХК	4 145,8	6,2
14	Монре даатгал ХХК	1 474,2	2,2
15	УБ хотын даатгал ХХК	1 151,8	1,7
16	Хаан даатгал ХХК	1 392,4	2,1
	<b>Дүн</b>	<b>66 604,7</b>	<b>100,0</b>

## 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2013 оны 3 дугаар улирлын байдлаар 17205.5 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 дахин өссөн байна.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 31.5 хувь, “Бодь даатгал” ХХК 11.5 хувь, “Миг даатгал” 9.4 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 55.3 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-13)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1 517,6	8,8
2	Бодь даатгал ХХК	1 976,6	11,5
3	Ган зам даатгал ХХК	35,6	0,2
4	Мандал женерал даатгал ХХК	624,9	3,6

5	МИГ даатгал ХХК	1 622,1	9,4
6	Монгол даатгал ХХК	5 418,9	31,5
7	Гэр даатгал ХХК	102,6	0,6
8	Моннис даатгал ХХК	47,1	0,3
9	Мөнх даатгал ХХК	181,7	1,1
10	Номин даатгал ХХК	410,5	2,4
11	Практикал даатгал ХХК	1 519,4	8,8
12	Тэнгэр даатгал ХХК	1 406,2	8,2
13	Соёмбо даатгал ХХК	1 608,7	9,3
14	Монре даатгал ХХК	611,5	3,6
15	УБ хотын даатгал ХХК	36,4	0,2
16	Хаан даатгал ХХК	85,7	0,0
	<b>Ä-Í</b>	<b>17 205,5</b>	<b>99,5</b>

## 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирлын харьцаагаар харьцуулахад 2013 оны 3 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 49.07 хувь “Соёмбо даатгал” ХХК 51.58 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-14)

/төгрөгөөр/

№	Даатгалын компаниудын нэрс	Орлогод тооцсон хураамж	Нөхөн төлбөр	Хувь
1	Ард даатгал ХХК	4 388 249 186,19	1 517 589 810,16	34,58
2	Бодь даатгал ХХК	5 486 427 292,86	1 976 649 725,85	36,03
3	Ган зам даатгал ХХК	397 607 046,53	35 551 690,00	8,94
4	Мандал женерал даатгал ХХК	2 251 184 992,30	624 976 310,58	27,76
5	МИГ даатгал ХХК	3 313 733 791,00	1 622 114 433,00	48,95
6	Монгол даатгал ХХК	11 043 097 360,00	5 418 879 878,00	49,07
7	Гэр даатгал ХХК	325 190 733,03	102 554 727,00	31,54
8	Моннис даатгал ХХК	391 257 892,37	47 137 149,00	12,05
9	Мөнх даатгал ХХК	775 774 457,00	181 678 387,00	23,42
10	Номин даатгал ХХК	890 887 522,67	410 455 141,74	46,07
11	Практикал даатгал ХХК	3 262 085 299,38	1 519 413 848,74	46,58
12	Тэнгэр даатгал ХХК	3 915 529 764,00	1 406 218 007,00	35,91
13	Соёмбо даатгал ХХК	3 118 632 292,00	1 608 668 680,45	51,58
14	Монре даатгал ХХК	1 348 422 823,05	611 464 199,00	45,35
15	УБ хотын даатгал ХХК	653 539 558,42	36 364 162,20	5,56
16	Хаан даатгал ХХК	347 130 091,00	85 695 859,20	24,69
	<b>ДҮН</b>	<b>41 908 750 101,80</b>	<b>17 205 412 008,92</b>	<b>41,05</b>

## 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 4721.4 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Ард даатгал” ХХК 2059.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт зах зээлийн 43.6 хувийг эзэлж байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна.



/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	2 059,5	43,6
2	Бодь даатгал ХХК	281,0	6,0
3	Ган зам даатгал ХХК	385,1	8,2
4	Мандал женерал даатгал ХХК	579,2	12,3
5	МИГ даатгал ХХК	101,3	2,1
6	Монгол даатгал ХХК	433,5	9,2
7	Гэр даатгал ХХК	126,5	2,7
8	Моннис даатгал ХХК	222,8	4,7
9	Мөнх даатгал ХХК	110,7	2,3
10	Номин даатгал ХХК	33,9	0,7
11	Практикал даатгал ХХК	73,0	1,5
12	Тэнгэр даатгал ХХК	599,2	12,7
13	Соёмбо даатгал ХХК	62,0	1,3
14	Монре даатгал ХХК	80,4	1,7
15	УБ хотын даатгал ХХК	99,2	2,1
16	Хаан даатгал	(525,9)	-11,1
	<b>Дүн</b>	<b>4 721,4</b>	<b>100,0</b>

## 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2013 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийн 15473.1 сая төгрөг буюу 26.7 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 33578.3 сая төгрөг буюу 57.9 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 130.0 сая буюу 0.3 хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц, 8845.9 сая төгрөг буюу 15.3 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй нөөц сан тус тус эзэлсэн байна.

/сая төгрөгөөр/

	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Сайн Дурын Даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	17 892. 6	25 995. 7	19 943. 8	23 944. 4
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	5 656. 8	4 576. 5	3 983. 1	6 250.2
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	226 .9	10 873. 5	11 013.1	87.4
	Учирч болзошгүй нөөц сан	11 632. 9	3 204. 9	966.6	13 871. 3
Албан Журмын Даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	9 737. 6	9 885 .8	9 989. 4	9 633.9
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	2 099. 6	3 608. 5	3 112. 3	2 595.7
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	98. 0	7 124 .7	7 180. 1	42.6
	Учирч болзошгүй нөөц сан	1 159. 3	832. 3	389 .7	1 601 .8

Дүн	48 503.7	66 101.8	56 578.2	58 027.3
-----	----------	----------	----------	----------

Албан журмын даатгалын нөөцийн санг жолоочийн хариуцлагын даатгалын хэлбэрээр тусад нь тайлагнасан болно.

## 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2013 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 18422.4 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Бодь даатгал” ХХК 15.84 хувь, “Монгол даатгал” ХХК 27.83 хувийг тус тус эзэлж нийт давхар даатгагчид төвлөрүүлсэн хөрөнгийн 43.67 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-17)

/сая төгрөгөөр/

№	Компанийн нэр	2013-III	
		тоо	хувь
1	Ард даатгал	1181,2	6,41
2	Бодь даатгал	2918	15,84
3	Тэнгэр даатгал	2970,2	16,12
4	Практикал даатгал	170	0,92
5	Миг даатгал	1706,9	9,27
6	Монгол даатгал	5127	27,83
7	Номин даатгал	36,6	0,20
8	Монре даатгал	86,6	0,47
9	Соёмбо даатгал	300,6	1,63
10	УБ хотын даатгал		-
11	Ган зам даатгал		-
12	Моннис даатгал	1041,8	5,66
13	Мандал женерал даатгал ХХК	2883,5	15,65
		<b>18422,4</b>	<b>100</b>

## 2.10 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТАЛААР

2013 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 16 компани бүгд жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалаар нийт 11,007.3 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч, үүнээс 10,774.6 сая төгрөг нь албан журмын даатгалын, 232,7 сая төгрөг нь сайн дурын даатгалын хураамжийн орлого бүрдүүлжээ.

Мөн тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалаар нийт 6,958.0 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон ба үүнээс 6,940.4 сая төгрөг нь албан журмын даатгалын, 17.5 сая төгрөг нь сайн дурын даатгалын нөхөн төлбөр байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж болон нөхөн төлбөрийн байдлыг даатгалын компаниар задлан харвал дараах байдалтай байна:

Даатгалын компани	Жолоочийн даатгалын хураамж	Даатгалын гэрээний тоо	Олгосон нөхөн төлбөр	Олгосон нөхөн төлбөрийн тоо
1."Ард даатгал" ХХК	829,266835.48	20,311	591,625,110.08	1,156
2."Бодь даатгал" ХХК	966,461,863.65	24,904	1,189,928,857.00	1,217
3."Ган зам даатгал" ХХК	9,505,055.50	60	9,676,300.00	8
4."Гэр даатгал" ХХК	204,678,251.75	3,958	59,148,903.00	157
5."Мандал генерал даатгал" ХХК	426,707,518.65	8,267	191,913,451.71	585
6."Миг даатгал" ХХК	1,490,794,031.00	37,952	661,089,760.00	1,528
7."Монгол даатгал" ХХК	2,688,133,030.01	67,979	1,568,363,944.13	3,505
8."Моннис даатгал" ХХК	31,232,885.99	159	2,910,900.00	5
9."Монре даатгал" ХХК	652,284,946.30	9,241	461,722,886.00	1,052
10."Мөнх даатгал" ХХК	164,340,152.00	4,334	156,565,175.00	552
11."Номин даатгал" ХХК	306,004,756.03	6,708	214,239,076.00	472
12."Практикал даатгал" ХХК	909,559,078.14	14,188	443,750,521.94	927
13."Соёмбо даатгал" ХХК	1,109,187,582.25	3,557	728,032,015.00	1,519
14."Тэнгэр даатгал" ХХК	691,993,729.31	18,016	629,523,389.00	1,384
15."Улаанбаатар хотын даатгал" ХХК	3,091,150.00	20	3,717,050.00	7
16."Хаан даатгал" ХХК	291,361,295.00	8,624	28,235,261.20	70
<b>Нийт</b>	<b>10,774,602,161.06</b>	<b>228,278</b>	<b>6,940,442,600.06</b>	<b>14,144</b>

Жолоочийн даатгалын хохирол нөхөлтийн харьцаа дундажаар 64.5 хувьтай байгаа нь нөхөн төлбөрийн үзүүлэлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

### 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр "Нэйшнл лайф даатгал" ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Байгуулагдсан цагаас хойшхи нийт хөрөнгийн хэмжээ 3789.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сүүлийн 4 жилийн мөн үеийн байдлаар дараах байдалтай байна. (График-9)

*/сая төгрөгөөр/*



Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс 61.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ

Урт хугацааны даатгалын компани 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 687.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 36.1 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 196.2 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 4 жилийн өмнөх үеэс хойш даатгалын хураамжийн орлого 4.3 дахин, нөхөн төлбөр 6.5 дахин, давхар даатгал 0.7 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

(Хүснэгт-19)

*/сая төгрөгөөр/*

	2010.9.30	2011.9.30	2012.9.30	2013.9.30
<b>Хураамжийн орлого</b>	160.5	227.9	430.4	687.8
<b>Давхар даатгал</b>	50.6	56.5	11.2	36.1
<b>Нөхөн төлбөр</b>	30.3	41.6	135.9	196.2

Тус компанийн даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр 2010 оноос тогтмол нэмэгдэж ирсэн байна.

### 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ одоогийн байдлаар 807.5 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 20.0 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-20)

*/сая төгрөгөөр/*

	2010.9.30	2011.9.30	2012.9.30	2013.9.30
<b>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</b>	-421.0	-658.1	-788.8	-807.5
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	-88.9	-183.5	-142.2	-37.2
<b>Нөөц сан</b>	69.2	164.7	449.9	810.7

2010 оноос нөөц сангийн тайланг тайлагнасан байна.

(Хүснэгт-21)

*/сая төгрөгөөр/*

Даатгалын нөөц	2010.9.30	2011.9.30	2012.9.30	2013.9.30
<b>Хувь оролцоотой гэрээний нөөц сан</b>				
<b>Хувь оролцоогүй гэрээний нөөц сан</b>	69.2	164.7	449.9	810.7
<b>Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан</b>				
<b>ДҮН</b>	69.2	164.7	449.9	810.7

Даатгалын нөөц сан 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 810.7 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 354.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд өмнөх 4 жилийн мөн үеийнхээс 11.7 дахин нэмэгдсэн байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ, ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 3 дугаар улиралд нийт 18 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 687.3 сая төгрөг болсон байна.

(Хүснэгт-21)

/сая төгрөгөөр/

№	Зуучлагч компанийн нэр	2012.09.30	2013.09.30	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	117,9	69,3	-48,6
2	“АМЕ” ХХК	85	88,7	3,7
3	“Ачит ундарга” ХХК	49,9	34,6	-15,3
4	“Лоялти солюшн” ХХК	52,3	30,9	-21,4
5	“Эм Жи Ай Би” ХХК	13,4	-	-13,4
6	“Ренессанс групп” ХХК	46,3	55,5	9,2
7	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	0	Түдгэлзүүлсэн	
8	"Юу ай би" ХХК	10,7	26,3	15,6
9	"Си эн эн икс" ХХК	49,4	90,3	40,9
10	Изи инвестмент ХХК	8,6	Түдгэлзүүлсэн	-8,6
11	Гэрэлт буян ундрах ХХК	0		0
12	Хас банк ХХК		16,3	16,3
13	Хадгаламж банк ХХК			0
14	Эс ай би эс ХХК			0
15	Пийс оф лайф ХХК		0,1	0,1
16	Эрсдлийн шийдэл ХХК		236,5	236,5
17	Хаан банк ХХК		15,3	15,3
18	Нэйшнл эженси		23,5	23,5
	<b>Нийт дүн</b>	<b>433,5</b>	<b>687,3</b>	

Тайлант оны хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад "Юу ай би" ХХК 15.6 сая төгрөгөөр, "Аме" ХХК 3.7 сая төгрөгөөр, "Ренессанс групп" ХХК 9.2 сая төгрөгөөр, "Си эн эн икс" ХХК 40.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, "Эм жи ай би" ХХК 13.4 сая төгрөгөөр "Ачит ундарга" ХХК 15.3 сая төгрөгөөр, "Асимон брокерс" ХХК 48.6 сая төгрөгөөр, "Лоялти солюшн" ХХК 21.4 сая төгрөгөөр, тус тус буурсан байна

2013 онд шинээр тусгай зөвшөөрөл авсан Хас банк ХХК, Пийс оф лайф ХХК, Эрсдлийн шийдэл ХХК, Хаан банк ХХК, "Нэйшнл эженси" ХХК-иудын нийт даатгалын зуучлалын орлогын хэмжээ 291.7 сая төгрөгт хүрсэн байна.

“Эрсдлийн шийдэл” ХХК нь нийт даатгалын зуучлалын үндсэн үйл ажиллагааны орлогын 34.5 хувийг эзэлсэн байна.

#### 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 170.0 сая төгрөг байна.

(Хүснэгт-22)

/сая төгрөгөөр/

№	Үнэлэгч компанийн нэр	2012.09.30	2012.09.30	Өсөлт бууралт
1	“Бест эстимэйт” ХХК	10,5	23,2	12,7
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	31,9	24,9	-7,0
3	“Файн эстимэйт” ХХК	0	0	0
4	“Итгэлт эстимэйт” ХХК	20,1	36,5	16,4
5	“Мега марз” ХХК	0	9,3	9,3
6	“Вендо” ХХК	15,5	9,1	-6,4
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0,06	0,3	0,34
8	"Жи ай си си" ХХК	2,3	28,2	25,9
9	"Арвижих эстимэйт" ХХК	3,8	9	5,2
10	"Юү энд эн" ХХК		2	2
11	"Тэгш сонголт эстимэйт" ХХК		0	0
12	"Ашид билгүүн" ХХК		27,4	27,4
	<b>Нийт дүн</b>	<b>84,16</b>	<b>170,0</b>	<b>85,84</b>

Тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Бест эстимэйт” ХХК 12.7 сая төгрөгөөр, Итгэлт эстимэйт” ХХК 16.4 сая төгрөгөөр, “Мега марз” ХХК 9.3 сая төгрөгөөр, Хөрөнгийн үнэлгээний төв 0.3 сая төгрөгөөр, “Жи ай си си” ХХК 25.9 сая төгрөгөөр, “Арвижих эстимэйт” ХХК 5.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Гэрэгэ эстимэйт” ХХК 7.0 сая төгрөгөөр, “Вендо” ХХК 6.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

2013 онд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Юү энд эн” ХХК, “Ашид билгүүн” ХХК-иуд нь нийт 29,4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

## ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэн дүгнэж үзэхэд даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо сүүлийн хоёр жилд эрс нэмэгдэх хандлагатай болсон байна. Эдгээрийн дийлэнхийг төлөөлөгч болон даатгалын зуучлагчийн тооны өсөлт байна. Арилжааны банкууд даатгалын зуучлалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсанаас хойш орон нутаг дахь салбарын тоо нэмэгдэж түүгээр дамжуулан даатгалын төлөөлөгчийн сургалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо нэмэгдэж байна. Сүүлийн 5 жилийн мөн үеийн байдлаарх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо даруй 2.0 дахин нэмэгдсэн байдалтай байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 дахин өсч 122.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс эргэлтийн хөрөнгө 105.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 61.7 хувийг эзэлж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн дийлэнх хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа нь дүрмийн сан болон нөөцийн сангаас хийгдэх хөрөнгө оруулалтын харилцах, хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалтад голлон байршуулж байгаатай холбоотой байна.

Үүнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 250 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”, 249 дүгээр тогтоолоор “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг тус тус шинэчлэн баталж “үл хөдлөх хөрөнгө”, “эд хогшил, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж”-д байршуулах дээд хувийг хувь тус тус нэмэгдүүлж өгсөн. Цаашид тайлант оны мөн үеэс эхлэн шинэчлэн батлагдсан журмаар тайлагнах бөгөөд энэ нь өмнөх үеийн даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд зөвхөн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө давамгайлж ирсэн нөхцөл байдалд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт хураамжийн орлого өмнөх оны үеэс 12 хувиар өсч 67.2 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан иргэдийн даатгалд хамрагдах тоо хэмжээ, даатгалын талаарх ойлголт, мэдлэг нэмэгдэж байгаатай холбоотой. Нөгөө талаас даатгалын хураамжийн орлогын өсөлт нь даатгалын нөхөн төлбөрийн өсөлтийг дагуулж байна. Тайлант оны мөн үед 17.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 дахин нэмэгдсэн байна. Тиймээс даатгалын хохирлын харьцаа сүүлийн жилүүдэд 30.0 хувийн дундаж үзүүлэлттэй байсан бол тайлант оны мөн үед 40.0 хувьд хүрсэн.

Даатгалын салбарын шинжилгээг тайлант оны мөн үеийн байдлаар санхүүгийн байдал, ашигт ажиллагааны түвшинд хийхэд дараах байдалтай байна.

1. Эргэлтийн харьцаа: Энэ нь эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрөө нөхөх чадвар хир зэрэг хангагдсан байгааг харуулдаг бөгөөд даатгалын компанийн онцлогоос шалтгаалаад богино хугацаат өр төлбөр дээр даатгалын нөөц санг нэмж тооцов. 
$$\text{Эргэлтийн харьцаа} = \frac{\text{Эргэлтийн хөрөнгө}}{\text{Нөөц сан} + \text{богино хугацаат өр төлбөр}}$$
 Энэ

үзүүлэлт нь 1.79:1 байгаа бөгөөд аж ахуй нэгж компаниудад 2:1 байвал боломжийн гэж үздэг.

2. Ашигт ажиллагааны үзүүлэлт: Даатгалын компаниудын нийт хөрөнгийн өгөөж 54 хувь, байна. *Нийт хөрөнгийн өгөөж=Даатгалын хураамж/Нийт хөрөнгө*) Нийт ашгийн түвшин 17 хувь, *(Нийт ашгийн түвшин= Татвар төлөхийн өмнөх ашиг/Орлогод тооцсон хураамж)*, өөрийн хөрөнгийн өгөөж 12 хувь *(Өөрийн хөрөнгийн өгөөж=Цэвэр ашиг/Өөрийн хөрөнгө)* буюу ашигт ажиллагааны үзүүлэлт хэвийн, нийт хөрөнгийн өгөөж сайн байна.

## ДААТГАЛЫН ГАЗАР